

## Дэлхийн залбирлын өдрийг тэмдэглэх нь —2024

**Магтаал—Бурхан бол агуу:** тэргүүн, бусдаас давамгай, зан чанар болон мөн чанарын хувьд илт давуу, хүч чадал, зэрэг, хүч, хэмжээсээр харьцуулашгүй аугаа.

Өө, ЭЗЭН минь, тэнгэрт болоод газар дээрх бүх юмс Таных учир агуу сүр, хүч чадал, яруу алдар, ялалт, цог жавхлан Таных билээ. Өө, ЭЗЭН минь, Та, бүхний дээр эрхэм дээд тэргүүн тул хаанчлал Таных билээ.

**1 Шастир 29:11**

Эзэн БУРХАН! Та зарцдаа алдар цуу, хүчирхэг мутраа харуулж эхэлсэн. Таных шиг ийм бүтээл, хүчит үйлсийг үйлдэж чадах бурхан, тэнгэр газрын хаана байна вэ?

**Дэд хууль 3:24**

ЭЗЭН аугаа бөгөөд машид ихээр магтууштай аугаа нь илрүүлшгүй.

**Дуулал 145:3**

Зүрхний чинь мэлмийг гийгүүлээсэй! Ингэснээр та нар Түүний дуудлагын найдварыг мөн ариун хүмүүс дэх Түүний өвийн алдрын баялгийг бас итгэдэг бидэнд хандсан Түүний хүч чадлын яндашгүй аугааг мэдэх болтугай. Энэ нь Түүний хүч чадлынх нь хүчний үйлдэл билээ.Тэрээр Христ дотор энэ л хүчээр нөлөөлж, Түүнийг үхэгсдээс амилуулаад тэнгэрлэг оршихуйд баруун гартаа залж.

**Ефес 1:18-20**

**Гэмшил—** Бурхан, хайр энэрлийнхээ учир намайг нигүүлсээч. Арвин их өршөөлийнхөө учир гэмт үйлдлийг минь арилгаач.

**Дуулал 51:1**

**Талархал—** Өөрийнхөө үгийн учир, Өөрийнхөө зарцыг ухааруулахын тулд зүрх сэтгэлийнхээ дагуу Та энэ бүх агуу үйлийг хийжээ. Ийм учраас Эзэн БУРХАН минь Та аугаа билээ. Учир нь Тантай адил хэн ч үгүй бөгөөд бидний чихээрээ сонссон бүхний дагуу Танаас өөр Бурхан байхгүй билээ.

**2 Самуел 7:21-22**

### Зуучлан залбирал:

#### Өөрсдийн хүүхдүүдийн төлөө

\_\_\_\_\_ Эзэн дотор хүч чадлаар зоригжин \_\_\_\_\_-ын сэтгэл болон байгаа бүхнээрээ Эзэний агуу байдлыг тунхаглана! \_\_\_\_\_ирэх үеийнхэнд ЭЗЭНИЙ магтаалыг,Түүний хүч чадал үйлдсэн гайхамшигт ажлуудыг нь тунхаглан ярина.

**(Дуулал 138:3, Лук 1:46, Дуулал 78:46)**

#### Алдагдсан хүмүүсийн төлөө

Хэрэв та Есүсийг Эзэн гэж амаараа хүлээн зөвшөөрч, Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэвэл, аврагдах болно;

**Ром 10:9**

#### Сурагчид

Гэлээ ч сүр хүчээ мэдүүлэхийн тулд Тэрээр нэрийнхээ төлөө тэднийг аварсан.

**Дуулал 106:8**

#### Багш нар

Эд баялаг, алдар хүндлэл аль аль нь Танаас ирдэг ба Та бүхнийг захирдаг. Таны мутарт эрх мэдэл, хүч чадал байдаг бөгөөд агуу болгох хийгээд хүчирхэгжүүлэх нь Таны мутарт атгаастай байдаг.

**1 Шастир 29:12**

#### Сургууль

Би Өөрийгөө өргөмжилж, Өөрийгөө ариусгаж, олон үндэстний нүдний өмнө Өөрийгөө мэдүүлэх болно. Тэд Намайг ЭЗЭН мөн гэдгийг мэдэх болно» гэв.

**Езекиел 38:23**

#### Ээжүүд хамтдаа залбирах нь

ЭЗЭН бүгдэд сайн. Түүний өршөөлүүд бүтээл бүхнийх нь дээр байна.Аяа ЭЗЭН, Таны бүтээл бүхэнТанд талархах бөгөөд бишрэлтнүүд тань Таныг магтацгаана.Тэд хаанчлалын тань жавхлангийн тухай ярьж, Таны сүр хүчний талаар өгүүлэх нь хүний хөвгүүдэд Таны хүчит үйлсийг болон хаанчлалын тань алдарт сүр жавхланг мэдүүлэхийн тулд болой.

**Дуулал 145:9-12**



ЭЭЖҮҮД ХАМТДАА ЗАЛБИРАХ НЬ  
ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА